



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 8/110

Хэрлэн сум

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, 14.7 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 20 дугаар тогтоолыг үндэслэн Мөрөн сумын нутаг "Чандгана" нэртэй газрын 165.031 га талбайг "Хэнтий ус" ХХК-д хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосугай.

2. Хайгуул хийх газар нутаг, талбайн нэр, талбайн хэмжээ, солбицол, хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралтаар баталсугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг чанд мөрдүүлж үйл ажиллагааны явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар дарга /Б.Сүнгээ/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Мөнх-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 572



Аймгийн Засаг даргын 2017 оны
03 дугаар сарын 21 өдрийн
захирамжийн хавсралт

№	Талбай байрших сумын нэр	Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/	Аж ахуй нэгжийн нэр	Солбицол								Хугацаа										
					Уртраг				өргөрөг														
					град	мин	сек	град	мин	сек	град	мин		сек									
1	Мөрөн	Чандгана	165.031	"Хэнтий Ус" ТӨХК	110	01	24.8	47	24	1.7	110	02	30	47	24	1.7	110	02	30	47	23	22.7	3 жил
					110	01	24.8	47	23	22.7	110	01	24.8	47	23	22.7							